

БАТЛАВ.
ЭРЧИМ ХҮЧНИЙ ДЭД САЙД,
АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА



М.БАЯРМАГНАЙ

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН 100 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Эрчим хүчний салбарын 100 жилийн хөгжлийн явцад хүрсэн ололт амжилт, тулгарсан хүндрэл бэрхшээл, сорилтод үнэлэлт дүгнэлт өгөх, ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох хүрээнд салбарын найдвартай байдлыг хангах, дэвшилтэт шинэ техник, технологийг нутагшуулах, нэвтрүүлэх, инновацийг хөгжүүлэх чиглэлээр эрдэмтэн, судлаачид, салбарын тэргүүлэх мэргэжилтнүүдийн хийсэн судалгаа, шинжилгээний ажлын үр дүнг хэлэлцэх, харилцан туршлага солилцох, эрчим хүчний хөгжлийн зорилтот хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээнүүдийг хангахад чиглэгдэнэ.

Хоёр. Хурлын агуулга, хамрах хүрээ

2.1. Эрчим хүчний салбарын 100 жилийн ойд зориулсан энэхүү эрдэм шинжилгээний бага хурал нь **“ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ БА ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ”** сэдэвтэй байна. Бага хуралд тавигдах илтгэлүүд нь Монгол Улсын эрчим хүчний салбарын аюулгүй байдлыг дээшлүүлэх, эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн шинэ техник, ногоон технологи (уламжлалт, сэргээгдэх, устөрөгч, цөмийн эрчим хүч, хүлэмжийн хийн ялгарал, ногоон хөрөнгө оруулалтын механизм)-ийг хөгжүүлэх, салбарын эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын чадавхи, эрчим хүчний хэмнэлтийг дээшлүүлэх, инновацийн чиглэлийн сэдвийг хамарсан байна.

2.2. Эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн, байгууллага, аж ахуйн нэгжийн судлаач, эрдэмтэн, эрдэм шинжилгээний ажилтан, эрчим хүчний үйлдвэр, компаниудын инженер техникийн ажилтнууд илтгэл бичиж оролцоно.

Гурав. Хугацаа, үе шат

3.1. Эрдэм шинжилгээний бага хурлыг 2 үе шаттайгаар зохион байгуулна.

3.2. I шат буюу салбар хурал: Эрчим хүчний салбарын үйлдвэр, компаниудын инженер техникийн ажилтан, их дээд сургуулийн судлаач, эрдэмтдийн дунд 2022 оны 4 дүгээр сарын 07-29-ний хооронд дараах 4 чиглэлээр цахим хэлбэрээр зохион байгуулагдана. Үүнд:

- 3.2.1.1. “Цахилгаан хангамж, техник технологи - ухаалаг сүлжээ” сэдвээр 2022 оны 4 дүгээр сарын 07;
- 3.2.1.2. “Дулаан хангамж - техник технологи” сэдвээр 2022 оны 4 дүгээр сарын 14;
- 3.2.1.3. “Эрчим хүчний эх үүсвэр – альтернатив эрчим хүч” сэдвээр 2022 оны 4 дүгээр сарын 20;

3.2.1.4. “Эрчим хүчний зах зээл - хөрөнгө оруулалт”сэдвээр 2022 оны 4 дүгээр сарын 29;

3.3. II шат буюу үндсэн бага хурал: Эрчим хүчний салбарын ололт амжилт, тулгарсан хүндрэл бэрхшээл, сорилтод үнэлэлт дүгнэлт өгөх, ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох хүрээнд эрдэмтэн, судлаачдын товлосон шинжилгээ, судалгааны ажлын үр дүн, мөн I шатнаас шалгарсан илтгэлүүдийг 2022 оны 5 дугаар сарын 23-нд зохион байгуулагдах үндсэн хурал (танхимд болон цахим хэлбэрээр)-д хэлэлцүүлнэ.

Дөрөв. Илтгэлд тавигдах шаардлага

4.1. Сэдвийн хүрээнд тулгамдаж буй асуудлыг дэвшүүлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлсон, баримт нотолгоонд суурилсан, шинэлэг санаа, практик ач холбогдол, эрэлт хэрэгцээг тодорхойлсон дүгнэлттэй байх;

4.2. Урьд нь хэвлэн нийтлэгдээгүй бүтээл байх;

4.3. Илтгэлийг “Эрдэм шинжилгээний өгүүлэл бичих заавар”-т нийцүүлсэн байх; Загварыг хавсаргав.

4.4. Илтгэл нь хураангуй, түлхүүр үг, оршил, судалгааны материал, арга зүй, үр дүн (график, хүснэгт, зураг), дүгнэлт, санал зөвлөмж, ашигласан материал, зохиогчийн товч намтрыг оролцуулан 6-8 нүүрэнд багтсан байна.

4.5. Илтгэл нь хэт онолын эсвэл ерөнхийлсөн байдлаас зайлсхийсэн байх шаардлагатай. Хуралд хэлэлцэгдэхээр сонгогдсон илтгэлийг “POWER POINT” дээр бэлтгэж ирүүлнэ.

Тав. Хурлын зохион байгуулалт

5.1. Эрдэм шинжилгээний бага хурлын I шатанд оролцох илтгэлүүдийг энэхүү удирдамжийн 4.3-т заасан шаардлагад нийцүүлэн 2022 оны 03 дугаар сарын 31-ний дотор дараах цахим хаягаар хүлээн авна.

- “Цахилгаан хангамж техник технологи - ухаалаг сүлжээ” илтгэлийг munkhbat73@energy.gov.mn;
- “Дулаан хангамж техник технологи” илтгэлийг ulemjd@must.edu.mn;
- “Эрчим хүчний эх үүсвэр – альтернатив эрчим хүч” tumenjargal@meei.energy.gov.mn, gal.purevdorj@yahoo.com;
- “Эрчим хүчний зах зээл-хөрөнгө оруулалт” илтгэлийг bolor-erdene@erc.mn;

5.2. II шатны үндсэн илтгэлийг 2022 оны 04 дүгээр сарын 30-ны дотор Ажлын хэсэгт enkhtaivan@energy.gov.mn мэйл хаягаар хүлээн авна.

Зургаа. Шагнал урамшуулал

6.1. Тусгай комисс I шат буюу салбар хурлын чиглэл тус бүрээс 3 илтгэл шалгаруулан дараах байдлаар шагнаж урамшуулна.

- Тэргүүн байр - Батламж, 1.000.000 төгрөг,
- Дэд байр - Батламж, 700.000 төгрөг,
- Гутгаар байр - Батламж, 500.000 төгрөг.

6.2. I шатны салбар хурлуудад тэргүүн байр эзэлсэн 4 илтгэлийг II шатанд хэлэлцүүлнэ.

7. Зохион байгуулагчидтай холбоо барих утас

Эрчим хүчний яам:

Ж.Гэрэл 99254489

Эрчим хүчний зохицуулах хороо:

Б.Болор-Эрдэнэ 99036282

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн:

М.Түмэнжаргал 99060812

ШУТИС-Эрчим хүчний сургууль:

Д.Үлэмж 99991236

“Эрчим хүчний ассоциац” ТББ:

Г.Пүрэвдорж 99092150

ДЭД АЖЛЫН ХЭСЭГ

---oOo---